

Анхдугаар ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 81 (2385)

1974 оны 10 дугаар сарын 28

ДАВАА

НЭГ НАСТАЙ МАЛ ХАШААЖИВ

Угтаал сумын Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаа, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс «Төл малыг онд мэнд оруулах зарим арга хэмжээний тухай» гаргасан тогтоолыг нийтэд таниулж сумын Намын хорооны товчооны хурлаар нэг настай малыг онд мэнд оруулах асуудал хэлэлцэж энэ ажлыг хариуцуулан захиргааны ажилд хяналт тавих комиссыг 7 хүний бүрэлдэхүүнтэй, намын хорооны дэргэд байгуулан ажилд нь оруулав.

Мөн намын нийт гишүүд, орлогчдын хүчийг зохион байгуулан суббогчид хийлгэж 80—90 торомтой ингэ өвөлжих хашааг барьснаар сум САА-н бүх нэг настай бод, бог мал саравчтай хашаагаар хангагдав.

Ж. МӨНХТОГОО

ЗӨВЛӨЛТ КУРГАНЧУУД КОММУНИСТ БАЙГУУЛАЛТЫН ЗАМД

Манай аймгийн шууд харилцаа бүхий Курганы мужийн хөдөлмөрчид ЗХУКН-ын XXIV их хурлын түүхэн шийдвэр, улс ардын аж ахуйг хөгжүүлэх IX таван жилийн төлөвлөгөөг биелүүлэхийн төлөө, зөвлөлтийн олон үндэстэн ястан, хөдөлмөрийн хүмүүстэй мөр зэрэгцэн коммунист бүтээн байгуулалтын аугаа их талбарт баатарлан ажиллаж байна.

Курган муж IX таван жилийн төлөвлөгөөт зорилтын эхний 3 жилийнхийг амжилттай биелүүджээ.

Өнгөрсөн хугацаанд үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүн 28,5 хувь өсч, 22 сая рублийн үйлдэхүүнийг төлөвлөгөөнөөс илүү борлуулсан нь ихээхэн ололт юм. Мөн хөдөлмөрийн бүтээмж 20,8 хувиар өссөний дотор машин үйлдвэрлэлд 33 хувиар дээшлэв.

Коммунист үйлдвэрлэлийн эн тэргүүний зорилтын нэг нь бүтээгдэхүүнээ дээд зэргийн чанартай гаргах явдал гэж Курганчууд үздэг байна.

Иймээс үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний нь 90-ээс дээш хувь тэргүүн зэргийн чанартай үнэлэгдэн 30 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүн улсын чанарын тэмдэг авчээ. Курганы мужийн үйлдвэрлэлийн нийт бүтээгдэхүүн 5 жилийн эхний үетэй харьцуулахад 1,4 дахин өссөн нь Курганы үйлдвэрлэлийн түргэн хурдныг харуулах баримт юм.

Өнгөрсөн 3 жил гаруй хугацаанд их барилгын хөрөнгө оруулалтад 1 миллиард 170 сая рублийг зарцуулснаар үйлдвэрлэлийн зохион байгуулалт технологи сайжирч, шинэ техник тоног төхөөрөмжийн гаргалт ихэссээр байна. Энэ таван жилд Курганы хотод өдлийн фабрик, Целинны бяслагны завод, Половинскийн хуурай сүүний завод зэрэг шинээр ашиглалтад орсон үйлдвэр соёлын орчин үеийн олон байгууламчуудыг дурьдаж болно.

Курган муж хөгжингүй аж үйлдвэрийн зэрэгцээ ихэд хөгжсөн газар тариалангийн үйлдвэрлэлтэй билээ. Тус муж 1959 онд өндөр ургаа авч, эх орондоо 90 сая пүү үр тариа тушааж Лениний одонгоор шагнагдсан байна. Газар тариалангийн үйлдвэрлэлд нээлт хийж, ихэд алдаршсан ЗХУ-ын Бүх Холбоотын ХАА-н ШУ-ны академийн хүндэт гишүүн, социалист хөдөлмөрийн баатар Т. С. Мальцев ажиллаж, мужийн хэмжээний тариалангийн үйлдвэрлэлийн технолог, удирдлага зохион байгуулалтын олон талтай ажилд асар их хувь нэмэр оруулсаар байна.

Ах дүү Курганы тариаланчид таван жилийн эхний 3 жилд дунджаар га-гаас 16,2 центнер ургаа авсан дотор 1973 онд 18 центнерийг авчээ.

Түрүүчийн таван жилийнхээс малын тоо толгой өссөний зэрэгцээгээр улсад тушаах мах 14 хувь, өндөг 45 хувь, ноос 22 хувиар нэмэгджээ.

Материал баялгийн үйлдвэрлэл ийнхүү хурдан явцтай хөгжиж нийгмийн баялаг арвижиж байгаагийн хирээр ард түмний аж байдал улам дээшилсээр байна. Тухайлбал: энэ 5 жилд ажилчин албан хаагчдын бодит цалин 22,5 хувиар өсчээ. ЗХУ-ын хүчирхэг эрхийн засгийн цаашид улам хөгжүүлэхийн улс төр, эдийн засгийн зорилтыг гүнээ ухамсарласан Курганы ажилч хичээнгүй ажилчид, тариачид, хөдөлмөрийн сэхээтнүүд коммунист хөдөлмөрийн хөдөлгөөн, социалист уралдаанаар жигүүрлэн ажиллаж эгнээ нээсээ гарамгай сайчуудыг төрүүлсээр байна.

Үүний нэг жишээ нь мөн хугацаанд үйлдвэр, ХАА-н тэргүүний сайчууд 4000 гаруй хүн одон медалиар шагнагдаж, социалист хөдөлмөрийн баатар долоо төрсөн явдал мөн.

Курган мужийн хөдөлмөрчид коммунист байгуулалтын аугаа их зорилтыг шийдвэрлэх үйлст коммунист ёсоор хөдөлмөрлөж бүтээн байгуулалтын их амжилт гаргаж байгаад Төв аймгийн хөдөлмөрчид ах дүүгийн гүн талархал дэвшүүлж байна.

Найрамдалт Курганы үйлдвэр хөдөө аж ахуй, соёл, ардын боловсрол, эрүүлйг хамгаалах, ахуй үйлчилгээний бүхий л салбарын ололт, ажлын шилдэг арга туршлагыг гүнзгий судаж эзэмших нь тус аймгийн хөдөлмөрчдөөс намынхаа зорилтыг биелүүлэхэд үнэтэй хувь нэмэр болох нь дамжиггүй.

ЭРХЭМ ДЭЭД ЗОЧНЫ АЙЛЧЛАЛД ӨНДӨР БҮТЭЭЛИЙН УРАЛДААН

Л. И. Брежнев тэргүүтэй ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМАУ-ыг тунхагласны түүхт 50 жилийн ойн баяр ёслолд оролцохоор эх оронд маань ирэх баярт өдрийг хөдөлмөрийн өрнүүн амжилтаар угтахын тулд Зуунмод хотын үйлдвэр, аж ахуйн газруудад ажилчдын цуглаанууд болж МАХН-ын XVI их хурлаас дэвшүүлсэн зорилт, V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлсэн амжилтаар эрхэм дээд зочноо угтъя гэсэн уриан дор нэрэмжит болзолт уралдаанууд зарлаж ажилчид нэмэлт үүрэг амлалт өргөнөөр авч байна. Аймгийн Хүнсний үйлдвэрт саяхан болсон ажилчдын цуглаан дээр тус үйлдвэр V таван жилийн төлөвлөгөөгөө эхний 4 жилд, 1974 оны жилийн төлөвлөгөөг 45 хоногийн өмнө биелүүлсэн дүнгээр ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчдийг угтах зорилт дэвшүүлж, үйлдвэрийн захиргаа, УЭ-ийн хорооноос ажилчдын дунд 35 хоногийн өндөр бүтээлийн уралдаан зар-

лав. Цуглаан дээр тус үйлдвэрийн улаан булан нийт улаан булангуудын дунд зарласан уралдаанд тохижилт, соёлжилт, зохиож буй ажлаараа улсын хэмжээнд 2 дугаар байрт шалгарч АУАУЭТ хорооны диплом, 600 төгрөгөөр шагнагдсаныг АУАУЭТХ-ны нарийн бичгийн дарга Бавуудорж гардуулав.

Аймгийн Холбооны газар, «Анхдугаар таван жил» сонинны СХ-ийн хэвлэл эх үйлдвэр, Ойн аж ахуй, Тээврийг удирдах газар, НААУГ-ууд өндөр бүтээлийн болон нэрэмжит, рапортын зэрэг олон хэлбэрээр 20—30 хоногийн социалист уралдаан зарлаж өнөө жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 45 хоногийн өмнө биелүүлэх зорилт дэвшүүлжээ.

Аймгийн Холбооны газар болсон ажилчдын цуглаан дээр МАХН-ын гишүүн Бадам, ЗХУКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга, манай хамгийн хүндэт зочин Л. И. Брежнев манай оронд айлчлах болсонд нийт коммунистуудынхаа нэгэн адил туйлын баяртай байгаагаа илэрхийлж, зарлаж

буй уралдаант хугацаанд V таван жилийн төлөвлөгөөг биелүүлсэн амжилтаар хүндэт зочиндоо бэлэг барихаа амлав.

Түүнчлэн НААУГ болсон ажилчдын цуглаан дээр 1974 оныхоо төлөвлөгөөг 3 сарын өмнө биелүүлсэн намын гишүүн С. Зэсэндэг өндөр бүтээлийн 30 хоногийн уралдаант хугацаанд V таван жилийн төлөвлөгөөг 100,5 хувиар биелүүлэх амлалт аваад уралдааны эхний 7 хоногт V таван жилийн төлөвлөгөөг 100,7 хувиар биелүүлж одоо ахин нэмэлт амлалт аваад ажиллаж байна.

НААУГ-аас ажилчдын дунд зарласан уралдааны эхний долоо хоногт зөвхөн ахуй үйлчилгээний комбинатын 23 ажилчин 1974 оныхоо төлөвлөгөөг 100—149,7 хувиар биелүүлжээ.

Ийнхүү ЗХУ-ын нам, засгийн төлөөлөгчид манай оронд айлчлан ирэх баярт үйл явдлыг угтсан социалист уралдаан тус аймаг даяар эрчимтэй өрнөж хөдөлмөрийн шинэ их бүтээл оргилсоор байна.

Ш. ЦЭРЭНДОО



Улаанбаатар хотыг БНМАУ-ын нийслэлээр тунхагласны 50 жилийн ойн социалист уралдааны тугийн дор тус аймгийн хөдөлмөрчид, үйлдвэрийн цех, сүргийн бэлчээр, ургацын далай, саалийн ээлнээс шинэ шинэ амжилтын дээжээр нийслэлийнхээ ойд бэлэг барилд аа. Нэгдэлч малчид маань өнгөрсөн оны мөн үеийнхээс буман төл илүү бэйжүүлэн төл бойжуулах улсын төлөвлөгөөг 110,9 хувь биелүүлсний дотор Батсүмбэр, Баянцагаан, Борнуур, Дэлгэрхаан, Жаргалант, Эрдэнэсант, Баянцагдмань, Угтаал сум, хороод төл бойжуулалтын төлөвлөгөөг 10—30 хувиар давууллаа.

Эх орны нийслэлийн ойд

Одоо аймгийн бүх малын 83,0 хувь нь отрын соргог бэлчээрээс оны таргыг авч яваагийн дотор БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, хоньчин Б. Ажваагийн малаа бэлчээрээр таргалуулдаг туршлагаар 122 суурийн, 256 малчин малдаа тарга авахуулж явна.

Эх орныхоо нийслэлийг сүү цагаан идээгээр хангах хүндтэй үүрэг хүлээсэн манай саальчид энэ оны өмнө сард өнгөрсөн оны мөн үеийнхээс хоёр сая литрээр илүү буюу 9,3 гаруй сая литр сүү улсад тушаагаад байгаагийн дотор Батсүмбэр, Заамар, Мөнгөнморьт, Баянцагдмань сум, хороо улсад тушаах сүүний төлөвлөгөөг 3—35,6 хувиар давуулсан амжилтаар нийслэлийн ойд бэлэг барив.

Манай тариаланчид 10 дугаар сарын 22-ны байдлаар 106,7 мянган тонн үр тариа, 10,8 мянган

тонн төмс 12,3 мянган тонн хүнсний ногоо, 45,9 мянган тонн тэжээлийн ургамал хураан аваад байна.

Мөн тус аймгийн үйлдвэрүүд энэ оны эхний 9 сард 10,3 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэн төлөвлөгөөгөө 113,4 хувиар биелүүлсэн амжилтаар Улаанбаатар хотын 50 жилийн ойг угтлаа.

Нийслэлийн ой угтсан уралдааны өдрүүдэд тус аймгийн үйлдвэр, ХАА, тээвэр, холбоо, соёлын зэрэг бүх салбараас өндөр бүтээлийн эзэн 150 гаруй хүн V таван жилийн төлөвлөгөөг хугацаанаас нь өмнө биелүүлж «V таван жилийн гавшгай» тэмдгээр өнгөрээ мялаав.

Ингэж тус аймгийн хөдөлмөрчид эх орны нийслэлийнхээ түүхт ойг амжилт бүтээлийн дээдээр угтлаа.

МАНАЙ СУРВАЛЖЛАГЧ

Монгол—Зөвлөлтийн найрамдлын сард

Зохиолч-сэтгүүлч В. Потанинтай сэтгүүлчид уулзав

Аймгийн сэтгүүлчдийн салбарын гишүүд бид Курган нутгийн алдарт зохиолч-сэтгүүлч Виктор Потанинтай сэтгүүлч зохиолчийн энгийн чөлөөтэй ярилцдаг тэр суудал дээр суугаад цөөхөн минут боловч ярилцах сайнхан завшаан тохиолдсон юм. Уулзалт ярилцлагад «Анхдугаар таван жил» сонинны хариуцлагатай эрхлэгч, сэтгүүлчдийн салбарын дарга Д. Товуу, аймгийн Намын хорооны нарийн бичгийн дарга, сэтгүүлч А. Давааням, мөн сонинны хариуцлагатай нарийн бичгийн дарга Б.Цэрэндорж, тус сонинны тусгай сурвалжлагч, аймгийн залуу зохиолчдын дугуйлангийн эрхлэгч Ш. Цэрэндорж нар оролцов.

Уулзалт дээр зохиолч-сэтгүүлч Виктор Потанин Монгол нутагт, тэр тусмаа өөрийн мужтай ажил төрлийн байнгын холбоотой тус аймагт айлчлан ирсэндээ баярласан сэтгэлээ илэрхийлэх сайхан үг олж ядан байлаа.

Эцэг Фёдер Станович Потанин нь Монголын ард түмний аз жаргалын төлөө хувьсгалын үйлт гарбие оролцож явсан болохоор энэ нутгийнхантай нүүр учран золгож нийгэм алгассан их хөгжлийг нүдээр үзсэндээ сэтгэл нь тэгтлээ догдлох нь аргагүй биз.

Виктор Потанин бол Зөвлөлтийн нэртэй зохиолч-сэтгүүлчийн нэг бөгөөд ЗХУ-ын зохиолчдын холбооны шалган байцаах комиссын гишүүний сонгуультай хүн.

Энэ хүний бичсэн 11 ном Зөвлөлтийн төдийгүй

Чехословак, Болгар, Франц уншигчдын хэзээний танил болсон тухай дэргэдэх нөхөр маань надад ярьж байв. Уянгалаг туужуудынх нь баатрууд эх орондоо коммунизм байгуулж байгаа жирийн хамтралчид юм.

Виктор Потанин өөрөө хөдөө тосгонд төрж, ээж Потанина Анна Тимофеевна хамтралчдын хүүхдэд багшлаж ЗСБНХОУ-ын гавъяат багш болжээ.

Эдний гэр бүлийн аз жаргал эндээс эхэлсэн болохоор түүний дуртай сэдэв нь хамтралын тухай байлгүй яахав.

Виктор Потанин Багшийн дээд сургуульд, дараа нь Москва хотод М. Горькийн нэрэмжит утга зохиолын дээд сургуульд төгсчээ.

—Эх орон, Лениний нам намайг ингэж анхаарч халамжилсан юм. Эх орноосоо олгосон их хувь заяаг ачлалаар хариулах ёстой.

Түүний энэ үгийг сонсч суухад хэн боловч өөрийн үүрэг хариуцлагаа өндөр ухамсарлаж чадвал зорсондоо хүрч, ихийг бүтээж болдгийг гэрчилнэ.

—Танай сайхан оронд зочилж та нартай учран ярилцаж байгаа маань ч гэсэн эх орноосоо надад хайрласан аз жаргал юм.

Энэ айлчлалын үеэр би хөдөлмөрийн 11 баатар төрүүлсэн Жаргалантын САА зэрэг Монголын цэцэглэн хөгжсөн хөдөө нутгийн амьд дүр зураг болсон олон газраар орж хөдөлмөрийн олон сайчуудтай уулзлаа.

Тэд миний зохиолын шинэ баатрууд болж ио-

монд маань амьдралаа ахин эхлэх нь дамжиггүй гэж сэтгэл догдлон ярих.

Үүнийг сонсоход хөдөлмөрийн хүний суу гайхамшиг юутай өргөн дэлгэр билээ гэж бодогдоно.

Виктор Потанины мэргэжил бол хоёр жигүүртэй юм.

—Зохиолч сэтгүүлчийн аль аль нь анхны эхлэн бичигчээс эхлэдэг болохоор энэ хоёр мэргэжлийн хооронд онцны ялгаа алга. Харин аль аль нь авъяас шаарддаг гэж ярьж буй энэ хүн эхлэн бичигчээс сэтгүүлч болж Курган мужийн «Залуу Ленин» гэдэг сонинд олон жил хариуцлагатай эрхлэгчээр нь ажиллажээ.

Курганд мужийн том сонин «Советский Заураль»-аас гадна район бүр өөрийн сонинтой бөгөөд тус мужид ЗХУ-ын сэтгүүлчдийн холбооны гишүүн 300 хүн ажилладаг гадна район бүрт сэтгүүлчдийн анхан шатны байгууллага, сургууль бүрт өсвөрийн сурвалжлагчдын дугуйлан байдаг аж.

Виктор Потанинаас сонингуудын арга ажиллагааны талаар сонирхолод сэтгүүлчдийн дунд нэрт сэтгүүлч Пурицагийн нэрэмжит уралдаан явуулж шалгарсан бүтээлд Пурицагийн нэрэмжит медаль олгодог.

Социалист уралдааныг сурталчлах талаараа Шадринскийн районы «Гавшгай» сонин их алдартай.

Гүүний эрхлэгч Ю. А. Михайлов гэж эдийн засгийн найруулал бичсэн хүн бий.

(Төгсгөл нь IV нүүрт)

ЭХ ОРНЫ НИЙСЛЭЛ



Нийслэлийн хөгжлийн тоо баримт

—Улаанбаатарт түлш, эрчим хүч, хөнгөн хүнс, ой мод, хэвлэлийн 60 гаруй үйлдвэр ажиллаж улсын аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 50 гаруй хувийг үйлдвэрлэж, нийслэлийн нийт ажиллагсдын 63,5 хувь материаллаг үйлдвэрлэлийн салбарт ажиллаж байна.

—Сүүлийн 10 жилд хотод шинэ орон сууцны хорооллууд, мах комбинат, хивсний үйлдвэр, архи пиwoны комбинат, 3 дугаар цахилгаан станц, биокомбинат зэрэг үйлдвэрүүд, нийтийн болон ахуйн үйлчилгээний олон арван объектуудыг барьж ашигдалтанд хүлээлгэн өглөө.

—Одоо өдөрт дунджаар 171 автобус, чиглэлийн ба шугамын такси 64 нийслэлийн хөдөлмөрчдөд үйлчилж байна. Улсын бүх ачаа болон зорчигч тээвэрлэлийн 48,7—84,3 хувийг нийслэлийн тээвэрчид гүйцэтгэж байна.

—Улаанбаатарт автомат телефон станц олон улсын холбоо «Орбита» станц, телевизийн төв ажиллаж байна.

Одоо нийслэлийн 3 айлын нэг нь телевизтэй боллоо.

—Авто тээврийн зам 2218,3 мянган хавтгай дөрвөлжин метр, 808,5 мянган мод сөөг, цэцэрлэгжүүлсэн талбай 3810,0 мянган квм болов. Сүүлийн 10 гаруй жилд орон сууцны 1, 2 дугаар 40 мянгат, 50 мянгат, 120 мянгат гатан хороолол, 5, 12, 15, 19 дүгээр хорооллууд цоо шинээр баригдаж 388,2 мянган хавтгай дөрвөлжин метр талбайтай орон сууцны барилга ашиглалтанд орлоо.

Мөн хотын цэвэр усны хангамж ариутгах татуур гын бүхэл бүтэн байгууламж бий болж хоногт 66,0 мянган шоо метр цэвэр, бохир усыг 156 км урт шугамд тээвэрлэж байна. Нийслэлийн худалдаа нийтийн хоолны газрууд улсын хэмжээний гүйцэтгэний 40 орчим хувийг гүйцэтгэж байна.

—Нийслэлийн ерөнхий боловсролын 68 сургуульд 68000 охид хөвгүүд, мөн 130 ясли, цэцэрлэгт 20-иод мянган хүүхэд багачууд хүмүүжиж байна.

Бас 6 их, дээд сургууль, 12 техникумд 10 гаруй мянган оюутан суралцаж байна.

Нийслэл хотод оршин суугч дөрвөн хүний нэг нь ямар нэгэн шатны сургуульд суралцаж, таван хүний нэг нь боловсрол эзэмшжээ.

Улаанбаатар хотод эмчлэн сувилах 30 гаруй болонц ажиллаж 1000 хүн тутамд эмнэлгийн 17 ор, 350 хүнд нэг их эмч ноогдож байна.

М. ДОЛЖИНСУРЭН

БНМАУ-ЫН НИЙСЛЭЛ—УЛААНБААТАР ХОТ

Л.ДУГАРЖАВ (Улаанбаатар хотын АДХ—ын гүйцэтгэх захиргааны нэгдүгээр орлогч дарга)

1924 онд хуралдсан улсын анхдугаар их хурлаар БНМАУ-ыг тунхаглан нийслэл хүрээг Улаанбаатар гэж нэрлэн БНМАУ-ын нийслэл болгон тунхагласны 50 жилийн ойг нийслэлийн хөдөлмөрчид, ард түмнийхээ хамт ёслол тэмдэглэж байна.

Улаанбаатар хотын аж ахуй, соёлын өрнүүн хөгжилт, хүн амын түргэн өсөлт, орчин үеийн хот байгуулалтын шаардлагыг тусгасан 2 дахь ерөнхий төлөвлөгөөг зохион хэрэгжүүлж байна.

Энэ ерөнхий төлөвлөгөөгөөр Улаанбаатар хотыг хот төлөвлөлтийн зарчмын дагуу аж үйлдвэр, үйлчилгээ, орон сууцны зохицтой хослол бүхий 4 том районд хувааж орон сууцны 19 хороолол байгуулах зорилт тавьж уг зорилтыг амжилттай хэрэгжүүлэхийн тул хотын барилгажилт,

аж ахуй, соёлын салбарт 1961—1970 онуудад 2 миллиард шахам төгрөгийн хөрөнгө оруулалт хийж бүтээн байгуулалтын асар их ажил хийсэн билээ. Мөн энэхүү шинэ ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад социалист хамтын нөхөрлөлийн орнууд, ялангуяа ЗХУ, түүний яруу алдарт барилгачид урьдын адил үнэлж баршгүй их хувь нэмэр оруулж байгаа нь нийслэлийн хөдөлмөрчдийн баяр бахдалыг зүй ёсоор төрүүлсээр байна.

Улаанбаатар хот тус улсын улс төр, нийгэм эдийн засаг, соёл, шинжлэх ухааны төв бөгөөд түүний олон улсын нэр хүнд улам бүр өсөн нэмэгдсээр байна.

Улаанбаатар хот ах дүү социалист хамтын нөхөрлөлийн орнуудын нийслэл хотуудтай нөхөрсөг сайхан харилцаа тогтоон тө-

лөөлөгчдөө солилцох, туршлага судлах зэргээр нягт хамтран ажиллах боллоо.

Энэ бүхэн нь Улаанбаатар хот манай орны улс төр, эдийн засаг, гадаад харилцааны төв болсны нотлон харуулж байна.

ЗХУ—ын тусламжаар нийт 200 шахам үйлдвэрийн газар байгуулсны дотор түлш эрчим хүч, барилгын материал, авто засвар, гурил, ноосны, бэлэн хувцасны үйлдвэрүүд зүй ёсоор орох бөгөөд тэдгээрийн дийлэнх нь Улаанбаатар хотод байгуулагджээ.

Нийслэлийн хэмжээгээр материаллаг үйлдвэрлэл ажиллагчдын 37,2 хувь нь аж үйлдвэрийн салбарт ажиллаж улсын хэмжээгээр бүх аж үйлдвэрт ажиллагчдын 35 хувь нь Улаанбаатарын үйлдвэрт ноогдож байна. Улаанбаатар хотын хөнгөн хүнсний үйлдвэр 1970 оны

байдлаар нийслэлийн бүх аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 75,1 хувь, үйлдвэрийн ажилчдын 66,2 хувийг эзлэж, эдгээр үйлдвэрүүд ард түмний өргөн хэрэгцээг хангаад зогсохгүй олон арван нэр төрлийн бүтээгдэхүүнийг гадаадад гаргаж байна.

Улаанбаатар хот БНМАУ-ыг аж үйлдвэр, ХАА-н орон болгох манай намын бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд чухлаар үйлдвэрийн хөгжлийн хурдац, өсөлтийн хэмжээгээр тэргүүлэх байр суурийг эзэлсээр байна.

Шинэ таван жилийн эхний 3 жилийн төлөвлөгөөг нийслэлийн аж үйлдвэр амжилттай биелүүлж, таван жилийн төлөвлөгөөг бүхэлд нь биелүүлэх боломжтой боллоо.

1973 онд нийслэлийн аж үйлдвэрийн газрууд төлөвлөгөөнөөс 15 сая төгрөгийн бүтээгдэхүүн

илүү үйлдвэрлэх амлалтаа 5,7 сая төгрөгөөр давуулсны дотор, үйлдвэр аж ахуй, соёл үйлчилгээний байгууллагын 10 мянган ажилчин уралдаанд авсан үүргээ 5—90 хоногийн өмнө биелүүлж 690 гаруй ажилчин V таван жилийн төлөвлөгөөгөө биелүүлсэн бөгөөд нийслэлийн аж үйлдвэрүүд нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэх 1974 оны эхний 9 сарын төлөвлөгөөг 101,9 хувь биелүүллээ.

Ардын засгаас авч явуулсан тууштай арга хэмжээний үр дүнд нийслэлийн хөдөлмөрчид ардын боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүлийг хамгаалах, биеийн тамир, урлаг, утга зохиол, соёлжилтын талаар асар их амжилт оллоо.

Нийслэлийн их, дээд тусгай мэргэжлийн дунд сургуульд 13,0 мянган оюутан сургаж суралцаж хотын ардын боловсролын системд нийтдээ 3600 гаруй багш, сурган хүмүүжүүлэгчид ажиллаж байна. Ерөнхий боловсро-

УЛААНБААТАР ХОТ БАЙГУУЛАГДСАНЫ 50 ЖИЛИЙН ОЙД

УЛААНБААТАРЧУУД УРГАЦ ХУРААЛТАНД

Ж.Жамъян (Ургац хураалтын улсын комиссын дарга)

Нийслэлийн хөдөлмөрчдийн амжилт нийтлэг сайхан ач холбогдолтой гэсэн атрын сангийн аж ахуйнханы яриаг олон удаа сонсч билээ.

Одоогоос 15 жилийн өмнө МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал болж, атар газрыг эзэмшиж эх орныхоо гурил будааг дотоодлоо үйлдвэрлэх түүхэн шийдвэр гаргасан юм.

Түүнээс хойш удсан ч үгүй нийслэлийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны хуваариар нийслэлийн ХЗЭ-ийн байгууллагуудад хялбарчлалт нийслэлийн үйлдвэр, албан байгууллагаас атрын САА-д очих залуучуудыг шилэн элсүүлж Угтаал, Зэлтэр, Дархан, Баянцогт зэрэг олон аж ахуйд очих тэднийг үдэх хөдөлмөрчдийн баярын цуглаан жанжин Сүхбаатарын нэрэмжит төв талбайд үе үе болж хөгжим эгшиглэн хүмүүсийн хөл хөдөлгөөн ихсэж авто ба ХАА-н машин техникийн сүрлэг цуваа баруун зүг чиглэн, атрын асуудал ярианы гол сэдэв болдог байв.

Тэр хавар эвлэлийн гишүүн Бадарчин ахлагчтай нийслэлийн 50 гаруй атарчин залуучууд, эвлэлийн гишүүн Б.Батчулуун ахлагчтай нийслэлийн 76 залуучууд машиндаа гэр майхнаа ачин Сүхбаатарын талбайд хөдөлмөрчдийн цуглаанаар үдүүлэн Дархан, Угтаалын САА-н суу-

рийн чулууг тавихаар явж байсан үе, одоогийн байдлыг зэрэгцүүлэхэд үлгэрийн явдал шиг сонин санагдана.

Нийслэлийн атарчин залуучууд суурийг нь тавьсан Дархан, Угтаал, Зэлтэр, Баянцогтын САА-нууд 1974 оны намрын ургац хураалтаар 5,8 сая пүүр тариа, 1,5 мянган тонн хүнсний ногоо хурааж, улсын төлөвлөгөөг 102—104 хувь, 38,5 мянган тонн өвс бэлтгэж улсын төлөвлөгөөг 101—106 хувь, сүрэл 17 мянган тонн бэлтгэж одоо тэвэрлэн тушааж байна.

Нийслэлийн атарчин залуучууд атрын фронт

дээр гарамгай гавъяа байгуулж, Угтаалаас трактор-комбайнч Г.Алтанхүү БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, Угтаалын САА-н даргаар 15 жил ажиллаж байгаа атарчин залуу Б.Батчулуун Сүхбаатарын одонгоор, мөн 1—3 удаа одон медалиар шагнагдсан хүмүүс 30 гаруй, 1—4 удаа улсын аварга комбайнч болсон Угтаалын Баатар, Жасрай, Очирбат, тракторч Доржпүрэв, Дарханы САА-н комбайнч Батбилэг, Чойсүрэн, Ламзав нар улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх V таван жилийн төлөвлөгөөний тэргүүн 4 жилд

(Төгсгөл нь IV пүүрт)

ШЕФДЭЭ ТУСЛАЖ БАЙНА

Малын зүй бус хорогдлыг багасгах арга хэмжээний тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 25 дугаар тогтоол, МАХН-Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалын албан даалгаврыг биелүүлж мал сүргийг онд мэнд оруулах, төл бүрийг мал болгох уриан дор нийслэлийн албан үйлдвэрийн газар, хөдөлмөрчдийн идэвх өрнөснөөр одоо хотын 130 байгууллага, 8 аймгийн ХАА-н 97 нэгдэлтэй шефийн холбоотой ажиллаж байна.

Тэдгээр байгууллагууд шеф нэгдэлдээ туслах

нэгдсэн төлөвлөгөө гаргажээ.Зудын байдалд орсон Завхан, Ховд, Дорно говь,Өмнөговь аймаг болон Төв аймгийн зарим нэгдлийн хүсэлтийг биелүүлэх боломжийг судлан шеф байгууллагын шугамаар өвс тэжээл, хүн хүч, тээврийн тусалцаа үзүүлэх, хэрэгцээт зүйлийг бэлтгэн хүргүүлэх ажил зохиожээ.

Үүний дунд сүүлийн 3 жилд 54 мянган гаруй хүн ажиллан малын хашаа 159, пүз 416, соёл үйлчилгээний барилга 38-ыг барьж 337 мянган тонн өвс бэлтгэж өгсөн байна.

Зөвхөн 1973 онд ХАА-н нэгдлийн 45 мянган төл бэйжүүлэн, 17 хашаа шинээр барьж 25 худаг шинээр гаргаж 26-г засварлажээ.

Үүний зэрэгцээ соёл үйлчилгээний барилга 9, төлийн пүз 256-г барьж 100 шахам айлыг оторт нүүлгэжээ. Мөн малын төрөл бүрийн тэжээл 16 мянган тонн, төлийн нэмнээ уут, элгэвч 31908 болон 590 метр эсгий, тэжээлийн онгоц, усан сан 1315-ыг бэлтгэж өгсөн нь нийтдээ бүрэн бус мэдээгээр 8,1 сая төгрөгийн зүйл бэлтгэжээ.

Түүнчлэн нэгдэл, бригадын төвд цахилгаан станц дулааны системийн холболт хийх малаа онд мэнд оруулах, төлийг гардалгүй хүлээн авч бэйжүүлэх зэрэг үйлдвэрлэлийн гол ажил дээр болзолт уралдаан өрнүүлж суурь малчид мал аж ахуйн мэрэгжилтнүүдийг шалгаруулан дүгнэх, тэргүүний хүмүүсийг нийслэлд урьж ирүүлэн хотын хоо хөгжилт цэцэглэлттэй танилцуулж зэрэг олон хэлбэрийн ажил зохиосон нь үр дүн өглөө. ХАА-н шеф нэгдэлдээ НАХЯ, түүний харьяа газар, авто тээврийн V бааз, мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэн, Тээврийн Яамны сэлбэг хангамжийн газар, Гадаад Явдлын Яам, ноос, гурил, нүүрсний нэгдлүүд зэрэг олон газар үлгэр жишээчээр туслаж ирлээ.

Б.САРАНТУЯА

ОЮУТНУУДЫН ТУСЛАЛЦАА

Нийслэлийн их, дээд, тусгай мэргэжлийн дунд сургуулиудын оюутан сурагчид 1974 оны зун хөдөлмөрийн гавшгай отряд 74-ийг байгуулан ажилласны дээр Төв аймгийн Угтаалын САА-д 100-гаад хүнтэй интернационал бригад байгуулан ажиллаж сайхан амжилт гаргалаа.



Арс ширний үйлдвэрийн нэгдлийн харьяа савхин эдлэлийн үйлдвэрийн одоогийн БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Ц.Амгалан V таван жилийн төлөвлөгөөг 1 жил 11 сард биелүүлсэн хөдөлмөрийн бахдам амжилтаар Улаанбаатар хотыг БНМАУ-ын нийслэлээр тунхагласны 50 жилийн ойг угтаа.

лын оройн ээлжийн ба эцнээ 10 сургуульд 3500 ажилчин залуучууд сурч байна.

1973-1974 оны хичээлийн жилийг 1940 онтой харьцуулахад нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн тоо 5 дахин, сурагчид, багш нарын тоо 21,5 дахин өслөө.

15 мянган хүний суудалтай төв цэнгэлдэх хүрээлэн, 1000 гаруй хүний суудалтай спортын төв ордон, «Найрамдал» парк, олон тооны биений тамир-рын талбай, танхим, цанын бааз, клуб зэрэг спортын газрууд ажиллаж урлагийн газрууд нэг ээлжинд 120—140 мянган хүнд үйлдэх чадвартай болтлоо хөгжлөө.

Хотын хөдөлмөрчдийн аж байдал соёлын хэмжээ жил ирэх тутам дээшилж байгаагийн нэг жишээ бол одоо өрх нэгбүр дунд жаар 6,9 төрлийн хэвлэл захиалан уншиж, радио цэг 35,5 хувь, телевизийн тоо 46,4 хувиар нэмэгдсэн явдал мөн.

Нам засгаас ард түмний материаллаг аж байдал эрүүдийг хамгаалах, ахуйн соёлжилтыг дээшлүүлэх талаар дэс дараатай арга хэмжээ авч ирсний үр дүнд хотын хүн ам 1970 оныхоос 6 дахин өсч, одоо 312 мянгад хүрч бүрэлдэхүүн нь залуужиж 70 гаруй хувийг 35 хүртэлх насны залуус, 45 хувийг 16 хүртэлх насны хүүхэд эзлэж байна.

Сүүлийн жилүүдэд зочид буудал, гуанз, зоогийн газар, үйлчилгээний төв, орон сууцны барилга, үсчин, гэрэл зургийн газар зэрэг ахуй үйлчилгээний олон цэг салбарыг шинээр нээн ажиллуулав.

Одоо хотын хэмжээгээр 130 гаруй цэцэрлэг, яслид 20-иод мянган хүүхэд өсөн хүмүүжиж, худалдаа нийтийн хоолны 400 гаруй цэг салбар үйлчилж байна.

Улаанбаатар бол тус улсын тээвэр, харилцаа холбооны том зангилгаа газар мөн. Нийслэлд тээвэр хөгжихийн зэрэгцээ

орчин үеийн харилцаа холбоо амжилттай хөгжиж ЗХУ-ын өгөөмөр тусламжаар орчин үеийн төхөөрөмжөөр тоноглогдсон АТС-уудыг байгуулан ашиглалтад оруулснаар нийслэлийн телефон цэгийн тоо 1970 оныг 1973 онтой харьцуулахад 11 хувиар өслөө.

Одоо бүх аймгийн төв болон социалист орнуудын нийслэлтэй шууд утсан харилцаатай болов.

Манай хотын барилгажсан талбай 5600 га, цэцэрлэгжүүлсэн талбай 380 га болж хүн амын 40 гаруй хувь нь тохилог орон сууцанд аж төрж байна.

Улаанбаатар хотын өнөөгийн эрчимтэй өсөлт хөгжил нь түүний хэтийн сайхан төлөвийг нээж байна.

Улс орны хөгжил, хотын хүн амын өсөлтийн дагуу Улаанбаатар хотыг 2000 он хүртэл хөгжүүлэх 3 дахь ерөнхий төлөвлөгөөний техник эдийн засгийн үндэслэл батлагдаад түүнийг зохиох ажил хийгдэж байна. Шинэ ерөнхий тө-

лөвлөгөөний үндсэн агуулга нь хотын үйлдвэрлэх хүчийг бүх талаар хөгжүүлэх, соёл шинжлэх ухааны цаашдын дэвшилийг хангах, хөдөлмөрчдийн сайн сайхан байдлыг хэл бэрэлтгүй дээшлүүлэх, тэдний ажиллах сурах ам тэднээс нөхцөлийг бүрэлдүүлэн улмаар Улаанбаатар хотыг үлгэр жишээ боловсон тохилог социалист хот болгон хувиргах явдал мөн.

Энэ төлөвлөгөө ёсоор Улаанбаатар хотын хүн ам 2000 он гэхэд дагуул хотын хамт 550 мянга болох бөгөөд иж бүрэн барилгажсан төлөвлөлтийн 4 район бүхий монголын уран барилгын өв уламжлал, орчин үеийн хот байгуулалтын ололтыг зохис той хослосон 9600 га талбайд 3—9, 12—16 давхар барилгууд сүндэрлэсэн хаш цагаан хот болно.

Нийслэлийн хөдөлмөрчид МАХН-ынхаа жолоодлогоор төрөлх хотоо улам цэцэглүүлэн хөгжүүлэхэд урьдын адил идэвхтэй хүчин байх болно.

Байгуулагдсаны нь 50 жилийн ойд

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ ТУРКМЕН УЛС

Хувьсгалын өмнөх Туркмен бол хаант Оросын хоцрогдсон хязгаарын нэг байсан бөгөөд бэлчээр услаж тариалдаг талбайн нилээд хэсэг нь баячуудын мэдэлд байсны дээр хүн амын 70 гаруй хувь нь ядуучууд байв.

Тариалангийн үйлдвэрлэлийг бүдүүлэг аргаар эрхлэж модон анжис, зээтүүгээр газраа боловсруулж ургацаа гараар хураадаг байжээ. Өнөөдрийн ЗСБН Туркмен улс Дундад азийн баруун хэсэг ЗХУ-ын хамгийн өмнөт хязгаарт оршдог 488,1 мянган хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэр, 2 сая 428 мянган хүн амтай юм. Туркменийн Комму-

нист нам 73 мянга гаруй гишүүдтэй. Туркменийн аж үйлдвэрээс гаргаж байгаа бүтээгдэхүүний хэмжээ нь Зөвлөлт засгийн 50 жилд 130 гаруй дахин нэмэгджээ. Одоо тус бүгд найрамдах улсын хоногтог зориулалттай газраа нефть нь 1924 онд гаргаж байсан бүх нефтээс 7 гаруй дахин их юм.

IX таван жилд Туркмен улсын аж үйлдвэрийн үйлдвэрлэл 64 хувиар өсч ялангуяа хий, нефть, химийн аж үйлдвэр өндөр хурдацтай хөгжиж байгаагийн дотор хий 5, нефть 61,5, цахилгаан эрчим хүч боловсруулалт 1,9 дахин өсчээ.

IX таван жилийн эхний

3 жилд ЗСБН Туркмен улсын аж үйлдвэр 5,4 миллиард рублийн бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь IX таван жилийн төлөвлөгөөнд зааснаас 40 сая рублийн бүтээгдэхүүнээр давжээ. Тус Бүгд Найрамдах Улсын ХАА-д хөвөн зонхилох байранд орлог бөгөөд хөвөн үйлдвэрлэлээр ЗХУ-д II байр эзэлдэг юм.

IX таван жилийн эхний 3 жилд жилийн дунджаар 953 мянган тонн хөвөн үйлдвэрлээд байгаа нь VIII таван жилийнхээс 230 шахам мянган тоногдоруу байна.

Услаж тариалдаг хөвөний талбай 1922 оныхоос 16,0 гаруй дахин өсчээ.

Тус Бүгд Найрамдах улс нь энэ онд 39,6 миллиард шоо метр хий боловсруулах гэж байгаан нь 1973 оныхоос 10,0 миллиард шоо метрээр өснө. ЗСБН Туркмен улс ЗХУ-ын хэмжээгээр энэ онд боловсруулах хийний бараг тэн хагас 15,6 сая тонн нефть үйлдвэрлэх юм. Зөвлөлт Туркмен улсын ажилчин, албан хаагчдын тоо 1973 онд 1924 оныхоос 15,8 дахин өсчээ.

Тавь шахам жилд ЗСБН Туркменийн улс ардын аж ахуйд оруулсан хөрөнгө 11 миллиард рубльд хүрчээ.

Зөвлөлт засгийн жилүүдэд Туркменийн тариалангийн талбай бараг 3 да-

хин, үүний дотор хөвөнийгийнх 10 гаруй дахин нэмэгдсэний гадна ХАА-н нийт бүтээгдэхүүн 1913 оны төвшингээс 5 гаруй дахингаар давжээ.

1973 онд тус улсын хураан авсан түүхийн хөвөнгөөр дэлхийг экваторынх нь шугамаар 40 дахин ороож хүрэхүйц метрийн өргөнтэй бөс бараа боловсруулж болохоор тийм их ургац хураажээ. Туркмен улсад шинжлэх ухаан, соёл, урлаг ихээхэн хөгжжээ. Одоо тус улсад дээд сургууль 6, театр, клуб, соёлын ордон 92,9 ажиллаж байна.

Мөн эрдэм шинжилгээний байгууллага 60 гаруй бий. Туркмен 10 мянган хүнд оногдох их эмчийн тоогоор Туркээс 4,5, Ираанаас 6,3, Иракаас 7,7 дахин их юм.

Н. ХАНДСҮРЭН

ЗӨВЛӨЛТ СОЦИАЛИСТ БҮГД НАЙРАМДАХ УЗБЕК УЛС

Узбекистан хувьсгалаас өмнө хаант оросын колони байсан бөгөөд аж үйлдвэр бараг хөгжөөгүй, ХАА-г бүдүүлэг аргаар эрхлэн явуулдаг байжээ. Хөдөлмөрийн олон түмэн хаант оросын болоод нутгийн феодалуудад давхар мөлжүүлж, бичиг үсэггүй гуйланчлал хоосрол, өвчин зовлонд нэрвэгдэж байв.

Агуу их октябрийн хувьсгал Узбекийн түүхэнд шинэ үеийг нээж одоо ЗСБН Узбек улс, ЗХУ-ын аж үйлдвэрийн чухал районуудын нэг болж, механикжсан усалаж тариалдаг газар тариалангийн том төв, хөвөнийн үндсэн бааз нь болж байна. ЗСБН Узбек улс ЗХУ-ын хамгийн өмнөт хязгаарт Дундад Азид оршдог бөгөөд 447,4 мянган кв км нутаг дэвсгэр, 13,5 сая хүн амтай, 100 гаруй ястан үндэстэнтэй юм. ЗХУКН-ын дайчин отряднуудын нэг Узбекийн коммунист нам 449,6 мянган гишүүд, орлогч гишүүдтэй. ЗСБН Узбек улс

хүнд аж үйлдвэр 1300 гаруй, аж үйлдвэрийн газар үйлдвэрлэлийн 100 гаруй салбартай болсны гадна 1913 онд бүхэл жилдээ үйлдвэрлэн гаргаж байсан бүтээгдэхүүнийг одоо 6-хан хоногт үйлдвэрлэдэг болжээ. Узбекийн аж үйлдвэрт трактор, ХАА-н болон хөвөн тариалах машинныг голлон үйлдвэрлэдэг. IX таван жилийн төлөвлөгөөний эхний 3 жилд тус улсын аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 27 хувиар өсч, 830 сая рублийн бүтээгдэхүүнийг төлөвлөгөөнөөс давуулж өгчээ. ХАА-н хөдөлмөрд өнгөрсөн 50 жилийн хугацаанд 100 гаруй сая тонн хөвөн үйлдвэрлэв.

Узбекийн ХАА, ЗХУ-д үйлдвэрлэж байгаа цагаан будааны 16, түүхийн хөвөний 70, амтат гуаны 23, каракул арьсны 38 хувийг тус тус гаргаж байна.

1973 онд түүхэндээ арвин их ургац авч 4 сая 900 мянган тонн цагаан алт улсад тушаажээ. Одоо Узбекийн ХАА-д 142 мян-

ган трактор, 27 мянган хөвөн хураагч машин, 40 гаруй мянган тээврийн машин ажиллаж байна.

Мөн 3,6 миллиард шоо метр ус хадгалах чадалтай аварга том ус хадгалагч 12 усан сан байгуулжээ.

1973-1974 оны хичээлийн жилд төрөл бүрийн сургуульд 4,7 сая гаруй хүн сурч байгаагийн дээр нь, дээд сургуульд 41 ажиллаж байна. Тус БН Улсад Эрдэм шинжилгээний 188 байгууллагат 23 мянга гаруй эрдэм шинжилгээний ажилтан ажиллаж байна.

Эмнэлгийн 133,9 мянган ор, 30,8 мянган их эмч, 94,4 мянган эмнэлгийн дунд мэргэжилтэн бүхий эмнэлгийн 1200 гаруй байгууллага ажилладаг. ЗСБН Узбек улсад 253 сонин, 62 төрлийн сэтгүүл, сэтгүүл маягийн хэвлэлийг нийтлэдэг 13 сая гаруй хувиар хэвлэн гаргадаг. Мөн 35,9 сая ном, сэтгүүл бүхий 6,0 мянга гаруй номын сан ажиллаж байна.

Ц. САРУУЛ

Улаанбаатарчууд ургац хураалтанд

Төгсгөл. Түрүүч нь III нуурт 7-9 жилийн ажил хийжээ. Манай эх орон атар газрыг эзэмшсэн 15 жилийн ургац хураах ажилд нийслэлийн 136 мянган хүн тариалангийн талбайд ажиллажээ.

Ургац хураалтанд ажилласан нийслэлийн хөдөлмөрчид атар газар эзэмшсэн 15 жилд 270 мянган тонн хүнсний ногоо хурааж, ангиж ялгах, ачиж буулгах ажлыг гүйцэтгэсэн гэсэн гадна 167,5 сая пүү үр тарианы чийгийг хатаах, цэвэрлэх, ачиж буулгах зэрэг нүсэр хөдөлмөр хийлээ. Намрын ургац ху-

раалтын үеийн үр тариа, хүнсний ногооны тээвэрлэлтэнд манай авто ба төмөр замын тээвэр үлэмж суурийг эзлэдэг.

Арван таван намрын ургац хураалтанд 25 мянган авто машин бүхий 30 орчим мянган тээвэрчид нийслэлийн байгууллагуудаас гарчур гац хураалтын 15 жилд 460 сая тонн кмын тээврийн үүрэг гүйцэтгэжээ. Нийслэл Улаанбаатар хотын байгууллага хөдөлмөрчдийн бүтээлч сайхан тусламж дэмжлэг нь хөдөө нутгийн хөдөлмөрчдийг үргэлж баярлуулан зоригжуулж байдаг.

Зохиолч-сэтгүүлч В.Потанинтай сэтгүүлчид уулзав

Төгсгөл. (Түрүүч нь II пүүрт)

Манай сэтгүүлчид ном бичдэг нь надад их таалагддаг. Зохиолч хүн ингэж сэтгүүлчийн ажлаар уран бүтээлийн замаа эхэлдэг юм гээд бид танай сонин сэтгүүлийг үзэж хөдөө нутгаар явахдаа тэргүүний хүмүүсийг өндөрт өргөж хөдөлмөрийн алдар гавьяаг сайн сурталчилдгийг мэдсэндээ бахтай байна.

Саяхан биднийг МАХ Н-ын Төв Хорооны үзэл суртлын хэлтэст нөхөр Ц.Хасбаатар хүлээн авч танай аймгийн сонин тухай асуусан. Түүний асуултанд өөрийнхөө ойлгож мэдсэний хирээр танай редакцийн болон сэтгүүлчдийн ажиллагааны тухай ярьсан юм.

Танай сонин ажил бол хүмүүс болоод хөдөлмөрийн түүхэнд яруу тод хуудсыг үлдээж, тэр нь

мөнхөд зузаарсаар байна.

Энэ хуудсууд сэтгүүлчдийн оюун ухаан, уран гарцаар бичигдэх бөгөөд эцсийн эцэст хөдөлмөрийн хүний өнөд дуурсах алдар гавьяа болж үлдэх юм.

Зохиолч В.Ф.Потанин тус аймагт байх хугацаандаа ямар сэтгэгдэлтэй байна гэсэн асуултанд —Хүний сэтгэл хөдөлнө гэдэг бол үг хэлж чадахгүй болдог юм байна.

Танай аймгийн тухай туйлын сайхан сэтгэл төрлөө. Бид өөрсдийнхөө ах дүү нарт хүрэлцэн ирээд байна. Бидний энэ халуун дотно уулзалт бол манай Урал нутгийн эрс тэс уур амьсгалыг өөрчлөнө гэдэгт итгэж байна гэв.

Элгэн халуун найрамдлын илч бадарсан тус уулзалт дээр зохиолч, сэтгүүлчид харилцан сонирхсон асуудлынхаа талаар ярилцлаа.

МАНЭИ СУРВАЛЖЛАГЧ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ



чоож эхний байрыг эзлэв. Д. РЕНЧИНДОРЖ

дын зөвлөлгөөнийг угтав. Ц. ПАГАМЖАВ

Аймгийн худалдаа бэлтгэлийн байгууллагуудын жижиглэн ба бөөний худалдааны яармаг саяхан Зуунмод, Улаанбаатар хо тод нээгдэн ажиллаа. Уг яармагт худалдаа бэлтгэлийн 15 анги, трест оролцож удаан гүйлгээтэй 100 гаруй мянган төгрөгийн барааг тэгшгэн, 79 мянган төгрөгийн жижиглэн худалдаа хийв. Тус яармагийн ажиллагаанд Баян, Угтаал, Баяндэлгэр сумдын ХБ-ийн ангиуд бусдаасаа идэвхтэй орол-

Баяндэлгэр сумын ХБ ангийн хамт олон 1974 оны төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхийн тулд социалист уралдааныг эрчимжүүлэн ажилласнаар энэ оны эхний 9 сарын бэрээ гүйлгээний төлөвлөгөөг 101,7, ном борлуулалтыг 104,7, нийтийн хоол (өөрийн бүтээгдэхүүнээр) 103,3, талх үйлдвэрлэлтийг 107,5 хувиар тус тус биелүүлэв.

Улсын бэлтгэлийн 36 нэр төрлийн зүйлээс 23 нэр төрлийн зүйлийг 100-114,3 хувиар биелүүлсэн амжилтаар аймгийн худалдааны тэргүүний ажилч-

Саяхан Зуунмод хотын төвд 1974-1975 оны хичээлийн жилд иргэний хамгаалалтын хичээлийг заах суртал нэвтрүүлэгчдийг бэлтгэх 3 өдрийн семинарыг 20 цагийн программаар явуулав.

Семинарын үеэр Нийтийн аж ахуйн үйлчилгээний газарт түгшүүрийн дохиогоор ажиллах дадлага сургууль хийж, семинарын дараагаар суртал нэвтрүүлэгчдийн зөвлөлгөөн болж иргэний хамгаалалтын ажлыг сайжруулах талаар санал со-

лилцов. Ж. СУНДУИ